

1. “Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлье” 3 сарын аяны хүрээнд 2018 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран тус аяны хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээлэл хийж, тэмцээн зохион байгуулж бүх байгууллагууд идэвхитэй оролцсон. Ард иргэдэд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвөлгөө өгч 300 ширхэг гарын авлага тарааж хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагааг сурталчилж ажилласан. Тарваган тахал өвчнөөс хамтдаа урьдчилан сэргийлэхийг уриалж байна.
2. 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Монгол улс дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн зөвлөх Ким Хан Чүл, Хүүхдэд ээлтэй орон нутаг хариуцсан зөвлөх Б. Зояа, Монгол Улсын БСШУСЯ-ны Хүүхдийн хөгжил, хамгаалал, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн доктор С.Болормаа нар Баян Өлгий аймагт хүрэлцэн ирж, Эрүүл мэндийн газарт Эрүүл мэндийн газрын дарга С.Айгүл, НЭМТ-ийн дарга Е.Сауле болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзан хэлэлцүүлэг зохион байгуулж, ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр боллоо.
3. Төрийн хяналт-иргэн таны төлөө сэдэвт сарын аяны хүрээнд зохион байгуулагдсан Хууль сурталчлах өдөрлөгийн үеэр Эрүүл мэндийн газраас эрүүл мэндийн тухай хууль болон эрүүл ахуйн тухай хуулийг сурталчлан 1400 ширхэг гарын авлага тарааж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 3 удаагийн ярилцлага өгч, Засгийн газрын 2018 оны 8 сарын 22-нд гарсан №258 тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор эрүүл мэндийн газрын ажилтнуудад сургалтыг зохион байгууллаа.

Зарим статистик үзүүлэлтүүд

Нийт төрөлт - 60

Амьд төрөлт - 60

Амьгүй төрөлт - 0

Дутуу төрөлт - 3

Нялхсын эндэгдэл - 1

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл - 0

Эхийн ноцтой хүндрэл - 0

Төрөлхийн гажиг - 1

Гэрийн төрөлт - 0

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 35 дугаар долоо хоногт нийт 2809 хүн үйлчлүүлсний 50 (2,2%) нь ГТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 1.1%-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна.